

## “ЭРЧИМБАЯН ӨЛГИЙ” ХК – НЫ ХАГАС ЖИЛИЙН

### ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2021.07.27

Тус компани нь Баян-Өлгий аймгийн төв бүх айл өрх, албан байгууллагуудад дулааны эрчим хүч үйлдвэрлэж түгээдэг.

2021 онд 110 хүний бүрэлдэхүүнтэйгээр эрчим хүчний зохицуулах хорооноос авсан дулаан үйлдвэрлэх, дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаагаа явууллаа.

Тус компаниас худалдан борлуулах дулааны эрчим хүчний үнэ тарифыг Эрчим хүчний зохицуулах хорооноос 2017 оны 02 сарын 09 өдрийн 53 тоот тогтоолын дагуу мөрдөж ажиллаж байна.

Дээрх тогтоолын хавсралтад зааснаар дулааныг нэмэгдсэн өртгийн албан татваргүйгээр албан байгууллагуудад 1411, орон сууцанд амьдардаг айл өрхүүдэд 780 төгрөг, ААНэгжүүд 1170 төгрөгөөр борлуулж байна.

Тус бүр 13Гкал/цаг – ийн хүчин чадалтай КЕ25-14 маркийн 3 зуух болон 20 Гкал/цаг - ийн хүчин чадалтай КВТС-20-150 маркийн 1 зуухтайгаар ажиллаж байна. КЕ25-14 нэг зуухыг тоног төхөөрөмжийг шинэчилж 2021 оны 01 сард ашиглалтанд оруулав. Үлдсэн 3 зуухаар өлгийн горим ажиллагааг хэвийн хангав.

Нийт 1679 хэрэглэгчээс айл өрх 1321, хувийн амины орон сууц 205, төсөвт байгууллага 49, аж ахуйн нэгж 104 байна.

Хагас жилийн тайлант хугацаанд 29,533,319 төгрөгийн цэвэр ашигтай гарсан боловч 901,369.8 мян.төгрөгийн дансны өглөгтэй, татварын албанд төлөх 508,585.4 мян.төгрөгийн, банкнаас авсан богино хугацааны 345,216.7 мян.төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй, урт хугацаат зээл 3,623,155.7 мян.төгрөг байна.

2021 оны хагас жилийн мөнгөн хөрөнгө 192,908.7 мян.төгрөг, дансны авлага 1,367,431.9 мян.төгрөг, бусад авлага 627,311.1 мян.төгрөг, бараа материал 439,859.7 мян.төгрөг, урьдчилж төлсөн орлого 42,363.7 мян.төгрөг эргэлтийн хөрөнгийн нийт дүн 2,669,875.1 мян.төгрөг байна.

Үндсэн хөрөнгө 7,088,126.4 мян.төгрөг, биет бус хөрөнгө 110,719.6 мян.төгрөг эргэлтийн бус хөрөнгийн нийт дүн 7,198,846 мян.төгрөг нийт хөрөнгийн дүн 9,868,721.1 мян.төгрөг байна.

Дансны өглөг 901,369.8 мян.төгрөг, цалингийн өглөг 37,372.6 мян.төгрөг, татварын өглөг 508,585.4 мян.төгрөг, НДШ-ийн өглөг 46,848.5 мян.төгрөг, богино хугацаат зээл 345,216.7 мян.төгрөг, хүүний өглөг 100.0 мян.төгрөг, бусад богино хугацаат өр төлбөрийн дүн 6,386.9 мян.төгрөг нийт богино хугацаат өр төлбөрийн дүн 1,848,583.7 мян.төгрөг, урт хугацаат зээл 3,623,155.7 мян.төгрөг байна.

Мөнгөн зарлагын дүн 3,781,789.6 мян.төгрөг байгаагаас ажилчидад олгосон мөнгөн зарлага 342,645.5 мян.төгрөг нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө 40,499.8 мян.төгрөг бараа материал худалдан авахад төлсөн мөнгө 89,314.8 мян.төгрөг ашиглалтын зардалд төлсөн мөнгө 222,871.7 мян.төгрөг түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгслийн үнэд 1,044,816.0 мян.төгрөг, хүүд төлсөн 346,586.1 мян.төгрөг, татварын байгууллагад 42,565.4 мян.төгрөг, даатгалын төлбөрт 4,194.2 мян.төгрөг тус тус төлсөн байна.

Компанийн 2021 оны хагас жилийн санхүүгийн тайланг 2021 оны 06 сарын 30 – ний өдрөөр тасалбар болгон гаргаж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан хугацаанд холбогдох байгууллагуудад хүргүүлсэн.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
ЕРӨНХИЙ НЯ-БО *М. Тилеуберди*



М. ТИЛЕУБЕРДИ  
К. ЕРБОЛАТ